



2020 оны 04 дүгээр сарын 10
№14 /1116/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Хэлэлцээр соёрхон
батлах тухай**

**Монгол Улсын
Ерөнхийлөгчийн
зарлиг**

**Шүүгчийг сонгон
шалгаруулах журам
батлах тухай**

**Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол**

**Үндэсний хөтөлбөр
батлах тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

148. Хэлэлцээр соёрхон батлах тухай 749

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ЗАРЛИГ**

149. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний
албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 18 750

150. Шүүгчийг сонгон шалгаруулах журам
батлах тухай Дугаар 19 750

151. Төрийн аудитын тэргүүн түшээ зэрэг
дэв олгох тухай Дугаар 24 756

152. Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон
тооны гишүүнд зэрэг дэв олгох тухай Дугаар 25 757

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ТОГТООЛ**

153. Үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 362 757

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ
ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ази, Номхон далайн худалдааны хэлэлцээрийг
Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар
хот

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон тул Балдангийн Уранцэцэг, Нанзадын Ганбаяр нарыг Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар
хот

Шүүгчийг сонгон шалгаруулах журам батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. “Шүүгчийг сонгон шалгаруулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2020 ны 02 дугаар сарын 21-ний
өдрийн 19 дүгээр зарлигийн хавсралт

ШҮҮГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Бүх шатны шүүхийн шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвшигчээс шалгалт авах, үнэлэх, дүгнэлт гаргах, сонгон шалгаруулах ажиллагаа /цаашид “сонгон шалгаруулалт” гэх/-г энэ журмаар зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, Шүүхийн захиргааны тухай хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3. Сонгон шалгаруулалт нь Шүүхийн мэргэшлийн хороо /цаашид “Мэргэшлийн хороо” гэх/-ны шалгалтын үнэлгээ, Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид “Ерөнхий зөвлөл” гэх/-ийн болон Монголын хуульчдын холбоо /цаашид “Хуульчдын холбоо” гэх/-ны дүгнэлт, Ерөнхий зөвлөлийн Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх саналаас бүрдэнэ.

1.4. Анхан шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтыг жилд хоёроос доошгүй удаа, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн сонгон шалгаруулалтыг сул орон тоо зарлагдах бүрд зохион байгуулна.

1.5. Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчийн шалгалтын арга, хэлбэр, үнэлэх аргачлалыг Мэргэшлийн хорооны саналыг үндэслэн Ерөнхий зөвлөл батална. Шалгалтын даалгаврын агуулга, нууцлалыг Мэргэшлийн хороо хариуцна.

1.6. Мэргэшлийн хорооны ажлын алба /цаашид “Ажлын алба” гэх/ нь шүүгчийн сонгон шалгаруулалтад техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлнэ.

1.7. Сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод байх, шударга ёсыг эрхэмлэх, хууль дээдлэх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

Хоёр.Шүүгчийн сонгон шалгаруулалтын төрөл, үнэлгээ

2.1. Сонгон шалгаруулалт нь дараах төрөлтэй байна.

- 2.1.1. анхан шатны шүүхийн шүүгчийн;
- 2.1.2. давж заалдах шатны шүүхийн шүүгчийн;
- 2.1.3. хяналтын шатны шүүхийн шүүгчийн;
- 2.1.4. анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн.



2.2. Мэргэшлийн хороо энэ журмын 2.1-т заасан сонгон шалгаруулалтын хүрээнд суурь болон тусгай шалгалтыг зохион байгуулж, шалгалт тус бүрийг 100 хүртэл оноогоор үнэлнэ. Нэр дэвшигч нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-4.1.9 дэх заалтад заасан шаардлагыг хэрхэн хангасныг шалгаж, үнэлгээ гаргана. Нэр дэвшигчийн Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэг, монгол хэлний бичгийн болон ярианы чадвар, хэрэглээний программ ашиглах чадвар, эрх зүйн баримт бичиг боловсруулах чадвар, хуульчийн ёс зүйн мэдлэгийг суурь шалгалтаар, салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар, салбар эрх зүйн мэдлэг /сорил/, ёс зүй, зан төлөв /намтар судлах/, мэргэшсэн байдлыг тусгай шалгалтаар үнэлнэ.

2.3. Суурь шалгалтыг энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан сонгон шалгаруулалтад орж буй нэр дэвшигчээс авна. Шүүгчээр ажиллаж байгаа нэр дэвшигчээс суурь шалгалт авахгүй.

2.4. Энэ журмын 2.1.1, 2.1.3-т заасан сонгон шалгаруулалтад орж буй нэр дэвшигч суурь шалгалтад авбал зохих 100 онооны 60 ба түүнээс дээш оноо авсан тохиолдолд тусгай шалгалт өгөх эрхтэй болно. Нэр дэвшигчийн суурь болон тусгай шалгалтын оноо тус бүр 60 ба түүнээс дээш байвал Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

2.5. Энэ журмын 2.1.2, 2.1.4-т заасан сонгон шалгаруулалтад орж буй нэр дэвшигчээс тусгай шалгалт авна. Нэр дэвшигчийн шалгалтын оноо 60 ба түүнээс дээш байвал Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн гэж үзнэ.

2.6. Шүүгч өөр дагнасан шүүхийн шүүгчид нэр дэвших тохиолдолд энэ журмын дагуу тусгай шалгалт өгнө.

2.7. Шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн нэр дэвшигч адил шатны болон өөр дагнасан шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох тохиолдолд Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасан хугацаанд суурь шалгалтын оноог нөөцийн онооноос тооцуулж болох бөгөөд дагнасан салбар эрх зүйн чиглэлээр тусгай шалгалт өгнө.

2.8. Сум дундын шүүхийн шүүгчийн шалгалтад тэнцэж, нөөцөд бүртгэгдсэн нэр дэвшигч нь Эрүү, Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн сул орон тоонд нэр дэвшихдээ тухайн салбар эрх зүйн чиглэлээр өгсөн шалгалтын үнэлгээг тооцуулж болно.

2.9. Мэргэшлийн хороо нэр дэвшигчийн шалгалтын үнэлгээг нэн даруй гаргаж, Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна.

2.10. Мэргэшлийн хорооны үнэлгээ Шүүхийн захиргааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д заасан хугацаанд хүчинтэй байх бөгөөд энэ нь нэр дэвшигч сонгон шалгаруулалтад дахин оролцох эрхийг хязгаарлах үндэслэл болохгүй.

Гурав. Анхан шатны шүүхийн шүүгчийн шалгалт

3.1. Суурь шалгалт:

- 3.1.1. Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэг /сорил/ 20 хүртэл оноо;
3.1.2. монгол хэлний бичгийн болон ярианы чадвар 20 хүртэл оноо;
3.1.3. хэрэглээний программ ашиглах чадвар 10 оноо;
3.1.4. эрх зүйн баримт бичиг боловсруулах чадвар 20 хүртэл оноо;
3.1.5. хуульчийн ёс зүйн мэдлэг /сорил/ 30 хүртэл оноогоор тус тус үнэлнэ.

3.2. Тусгай шалгалт:

- 3.2.1. салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 40 хүртэл оноо;
3.2.2. салбар эрх зүйн мэдлэг /сорил/ 20 хүртэл оноо;
3.2.3. ёс зүй, зан төлөв /намтар судлах/ 30 хүртэл оноо;
3.2.4. мэргэшсэн байдал /нэр дэвшиж буй дагнасан шүүхийн салбар эрх зүйн чиглэлээр хамгаалсан боловсролын зэрэг, эрдмийн бүтээл зэргийг харгалзах/ 10 оноогоор тус тус үнэлнэ.

Дөрөв. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн шалгалт

4.1. Тусгай шалгалт:

- 4.1.1. хууль хэрэглэх мэдлэг, ур чадварыг 40 хүртэл оноо;
4.1.2. шүүн таслах ажлын туршлага 30 хүртэл оноо;
4.1.3. магадлал бичих ур чадвар 30 хүртэл оноогоор тус тус үнэлнэ.

Тав. Хяналтын шатны шүүхийн шүүгчийн шалгалт

5.1. Суурь шалгалт:

- 5.1.1. Үндсэн хуулийн эрх зүйн мэдлэг /сорил/ 20 хүртэл оноо;
5.1.2. эрх зүйн баримт бичгийн төсөл боловсруулах чадвар 20 хүртэл оноо;
5.1.3. монгол хэлний бичгийн болон ярианы чадвар 10 хүртэл оноо;
5.1.4. хэрэглээний программ ашиглах чадвар 10 хүртэл оноо;



5.1.5. шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх ур чадвар 20 хүртэл оноо;

5.1.6. хуульчийн ёс зүйн мэдлэг /сорил/ 20 хүртэл оноогоор тус тус үнэлнэ.

5.2.Тусгай шалгалт:

5.2.1. салбар эрх зүйн мэдлэг /сорил/ 15 хүртэл оноо;
5.2.2. салбар эрх зүйн хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 25 хүртэл оноо;

5.2.3. хууль тайлбарлах ур чадвар 20 хүртэл оноо;
5.2.4. ёс зүй, зан төлөв /намтар судлах/ 30 хүртэл оноо;
5.2.5. мэргэшсэн байдал /нэр дэвшиж буй дагнасан шүүхийн салбар эрх зүйн чиглэлээр хамгаалсан боловсролын зэрэг, эрдмийн бүтээл зэргийг харгалзах/ 10 оноогоор тус тус үнэлнэ.

Зургаа. Ерөнхий шүүгчийн шалгалт

6.1. Тусгай шалгалт:

6.1.1. манлайлал /ёс зүй, зан төлөв/ 30 хүртэл оноо;
6.1.2. хууль хэрэглэх мэдлэг, ур чадвар 40 хүртэл оноо;
6.1.3. шүүн таслах ажиллагааны туршлагыг 30 хүртэл оноогоор тус тус үнэлнэ.

Долоо. Шүүгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

7.1. Нэр дэвшигч нь анхан шатны шүүхийн шүүгчийн хэд хэдэн чиглэлээр сонгон шалгаруулалтад бүртгүүлж болно.

7.2. Анхан шатны шүүхийн шүүгчийн шалгалтыг бүртгэх хугацаанаас 45, сул орон тооны сонгон шалгаруулалтыг 14-өөс доошгүй хоногийн өмнө зарлана.

7.3. Ажлын алба шалгалт эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө шалгалтын хуваарийг Ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байршуулна. Шалгалт явуулах газар, огноо, эхлэх цагийг хуваарьт тусгасан байна.

7.4. Бүртгэлтэй холбоотой гомдлыг нэр дэвшигчдийг бүртгэсэн талаар нийтэд албан ёсоор мэдээлснээс хойш ажлын 3 өдрийн дотор Ерөнхий зөвлөлд бичгээр гаргана.

7.5. Ерөнхий зөвлөл гомдлыг үндэслэлтэй эсэхийг нягтлан шалгаж хариуг бичгээр өгнө.

7.6. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн, худал мэдүүлсэн

нь илэрсэн тохиолдолд нэр дэвшигчийг бүртгэлээс хасаж, бүртгэлийг хүчингүйд тооцох эсэхийг Ерөнхий зөвлөл шийдвэрлэнэ.

Найм. Нэр дэвшигчид хориглох зүйл

8.1. Нэр дэвшигчид дараах зүйлсийг хориглоно:

8.1.1. шалгалтын хэвийн үйл ажиллагаанд саад учруулах;

8.1.2. шалгалт эхлэх хугацаанаас хожимдох;

8.1.3. шалгалтын танхимд хууль, хуулийн тайлбар, ном, гарын авлагыг файл болон цаасан хэлбэрээр, гар утас, чихэвч, зөөврийн компьютер, аудио, видео техник хэрэгсэл, ноорог цаас, дэвтэр, үзэг, харандаа, флаш, зургийн аппарат зэрэг адилтгах бусад зүйлс авч орох, ашиглах;

8.1.4. шалгалтын программд нэвтрэх зөвшөөрөл өгөөгүй байхад түрүүлж нэвтрэх;

8.1.5. шалгалтын явцад бусдад саад учруулах, ярилцах, бусдын гүйцэтгэлийг харах, ашиглах;

8.1.6. өөр хүнийг шалгалтад оруулах, суудлын дугаарыг сольж суух;

8.1.7. шалгалтын материалд тэмдэг, тэмдэглэгээ хийх /Тэмдэг, тэмдэглэгээ гэдэгт юуг ойлгохыг Мэргэшлийн хороо тухай бүр шийдвэрлэнэ/;

8.1.8. сонгон шалгаруулалтад оролцогч сонгон шалгаруулалт зарласнаас эхлэн өргөн мэдүүлэх хүртэл хугацаанд Ерөнхий зөвлөл болон Мэргэшлийн хорооны гишүүдтэй сонгон шалгаруулалттай холбоотой асуудлаар биечлэн уулзах, утсаар ярих, цахимаар харилцах;

8.1.9. шалгалтын дүн, үнэлгээнд урьдчилан нөлөөлөх гэсэн аливаа хууль бус оролдлого хийх.

8.2. Энэ журмын 8.1-д заасныг зөрчсөн тохиолдолд танхимд нэвтрүүлэхгүй байх, тухайн нэр дэвшигчийн шалгалтыг хүчингүй болгож, танхимаас чөлөөлөх арга хэмжээ авна.

Ес. Дүгнэлт гаргах

9.1. Мэргэшлийн хороо нь сонгон шалгаруулалтад тэнцсэн шүүгчид нэр дэвшигчдийн нэгдсэн үнэлгээг сонгон шалгаруулалт дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

9.2. Хуульчдын холбоо нэр дэвшигчдийн нэрийн жагсаалт хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан дүгнэлтийг гарган Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.



9.3. Энэ журмын 9.2-т заасан дүгнэлт ирсний дараа шүүгчийн албан тушаалын сул орон тоонд нэр дэвшигч Ерөнхий зөвлөлийн ярилцлагад тухай бүр оролцоно.

9.4. Ерөнхий зөвлөл сул орон тоонд нэр дэвшигчтэй ярилцлага зохион байгуулж, дүгнэлт гаргана.

9.5. Ерөнхий зөвлөлийн дүгнэлт гарснаас хойш ажлын 2 өдрийн дотор нэр дэвшигчийн www.shuugch-songon.mn цахим хуудсанд бүртгүүлсэн цахим хаягаар мэдээлнэ.

Арав. Гомдол гаргах, шийдвэрлэх журам

10.1. Сонгон шалгаруулалттай холбоотой гомдлыг дор дурдсан хугацааны дотор Мэргэшлийн хороонд бичгээр гаргана:

10.1.1. шалгалтын төрөл тус бүрийн үнэлгээтэй холбоотой гомдлыг нэр дэвшигчид танилцуулснаас хойш ажлын 1 өдрийн дотор;

10.1.2. суурь шалгалтын болон нэгдсэн үнэлгээтэй холбоотой гомдлыг нийтэд албан ёсоор мэдээлснээс хойш ажлын 3 өдрийн дотор.

10.2. Энэ журмын 8.2-т заасны дагуу гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэр гарсан даруй Мэргэшлийн хороонд бичгээр гаргана.

Арван нэг. Өргөн мэдүүлэх санал хураалт

11.1. Шүүгчийн албан тушаалын сул орон тоонд нэр дэвшигч тус бүрийг Ерөнхий зөвлөл хуралдаанаараа хэлэлцэж, олонхын саналаар сонгон шалгаруулна.

11.2. Ерөнхий зөвлөлийн хуралдаанаас олонхын санал авсан нэр дэвшигчийн нэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж, Ерөнхий зөвлөлийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 24

Улаанбаатар
хот

Төрийн аудитын тэргүүн түшээ зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3.1 дэх заалт, 12.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын Ерөнхий аудитор Доржсүрэнгийн Занданбатад Төрийн аудитын тэргүүн түшээ зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 25

Улаанбаатар
хот

**Санхүүгийн зохицуулах хорооны
дарга, орон тооны гишүүнд зэрэг
дэв олгох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Улсын Их Хурлын 2006 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дарга, орон тооны гишүүнд зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүн, дэд дарга Түдэвийн Цэрэнбадрал, Нанжидын Хүдэрчулуун нарт Тэргүүн түшээ зэрэг дэв олгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**ХАЛТМААГИЙН
БАТТУЛГА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 9 дүгээр
сарын 25-ны өдөр

Дугаар 362

Улаанбаатар
хот

**Үндэсний хөтөлбөр батлах
тухай**

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр III”-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.



3. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган, олон улсын байгууллага, гадаадын зээл тусламжид хамруулах, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Ч.Улаан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Ч.УЛААН

Засгийн газрын 2019 оны
362 дугаар тогтоолын хавсралт

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ НИЙГМИЙН ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР-III

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Хоршооны тухай хуулийг баталсан бөгөөд үүнээс хойш 1998 онд шинэчлэн найруулж, 2002, 2004, 2005, 2011 онд тус тус 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг Засгийн газрын 1998 оны 145, 2009 оны 173 дугаар тогтоолоор батлан хэрэгжүүлсэн. Засгийн газраас 2003 оныг “Хоршоог дэмжих жил” болгон зарлаж, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-I”-ийг 1998-2006 онд, “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-II”-ийг 2009-2017 онд хэрэгжүүлсэн нь хоршооллын хөдөлгөөнд чухал түлхэц болсон.

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр II”-ийн хэрэгжилтэд хийсэн хяналт шинжилгээгээр хоршоо байгуулах оролцогчдын идэвх санаачилга нэмэгдэж хоршоо болон гишүүдийн тоо, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ өссөн. Гэвч Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр хоршооны салбарын асуудлыг хариуцах яам нь тодорхойгүйн улмаас 2015-2016 онд салбарын эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ орхигдсон, төсөв хөрөнгөгүйгээс хоршоог хөгжүүлэх чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй, үр дүн гараагүй байна. Хоршооны удирдлага, гишүүдийг олон улсын болон дотоодын холбогдох байгууллагаас зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, хуралд хангалттай сайн хамрагдсан хэдий ч нэвтрүүлсэн шинэ санаа санаачилга дутмаг, аймаг, нийслэл тус бүр дэд

хөтөлбөр батлуулан хэрэгжүүлэх талаар тусгасан боловч орон нутгийн байгууллагатай хамтран ажиллах талаар дутагдалтай ажилласан гэж дүгнэжээ. Цаашид салбарын эрх зүйн орчныг сайжруулах, төсөв хөрөнгийг хангалттай батлан хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд орон нутаг, бусад төсөл хөтөлбөртэй уялдаатай ажиллаж салбарын хөгжлийн түвшинг шинэ шатанд гаргах шаардлагатай гэж зөвлөсөн байна.

Хоршоо нь өрхийн жижиг бичил бизнесээр хязгаарлагдахгүй бүс нутаг, тухайн баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд нэгдэж, хөдөлмөрөө хоршин, хүртэх орлого, ашгаа нэмэгдүүлэх боломжтой бөгөөд хүн амын ядуурал, ажилгүйдэл нэн ялангуяа хөдөө, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал хувь нэмэр оруулдаг салбар юм. Үндэсний статистикийн хорооны мэдээгээр улсын хэмжээнд 4377 хоршоо бүртгэлтэй байгаагаас 3693 хоршоо нь аймгуудад, 684 нь Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байна. Хоршоо нь улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжийн дөнгөж 2.8 хувийг эзэлж байна.

Монгол Улсын нийт 21 аймагт 2018 онд хийсэн хоршоодын хөгжлийн үнэлгээнд орон нутгийн нийт 3693 хоршоо хамрагдсанаас тогтвортой өсөлттэй 239, үйл ажиллагаа нь тогтворжиж буй 580, идэвхижиж буй 877, идэвхгүй буюу үйл ажиллагаа нь зогсонги 1324 хоршоо байна. Үнэлгээнд хамрагдаагүй 673 хоршоо нь бүртгэлтэй боловч бодитой оршин тогтнодог эсэх, хоршооны зарчмаар ажилладаг эсэх нь тодорхойгүй байна.

Улсын хэмжээнд явагдсан хоршоодын хөгжлийн үнэлгээний дүн (2018 он)

| Ангилал | Хоршооны тоо | Эзлэх хувь |
|------------------------------------|--------------|------------|
| Үнэлгээнд хамрагдаагүй | 673 | 18.2 |
| Идэвхгүй буюу зогсонги | 1324 | 35.9 |
| Идэвхижиж байгаа | 877 | 23.7 |
| Үйл ажиллагаа нь тогтворжиж байгаа | 580 | 15.7 |
| Тогтвортой хөгжиж буй | 239 | 6.5 |
| Дүн | 3693 | 100 |

Тогтвортой ажиллаж буй хоршоодын 9 орчим хувь нь хадгаламж, зээлийн чиглэлээр, 6 хувь нь дундын хоршоо бөгөөд дийлэнх нь гэр бүлийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Хоршоог гишүүдийн нийгэм, соёлын хэрэгцээг хангах зорилгоор хоршиж хөдөлмөрлөх биш “хоршоо” гэдэг нэрийг ашиглаж, нэг хүний эрх ашгийн төлөө байгуулах явдал түгээмэл



гарч байна. Хоршооны удирдлагын менежмент муу, гишүүдийн өмнө хүлээх хариуцлага тодорхойгүй, банкнаас зээл авах барьцаа хөрөнгө дутагдалтай, хоршооны гишүүдийн ажлын үнэлэмж, урамшуулал тогтворжоогүй, бизнесийн төлөвлөлт байхгүйгээс хоршоо бусад бизнесийн хэлбэртэй харьцуулахад өрсөлдөх чадавх сул, гишүүдийн амьдралд бодит өсөлт, дэвшил гарч хуримтлал үүсэх, шинэ технологи, ноу хау нэвтрүүлэх зэргээр бие даан хөгжиж чадахгүй байна. Тухайлбал судалгаанд хамрагдсан нийт хоршоодын 8.7 хувь нь огт орлого олоогүй, 54 хувь нь нэг сая хүртэлх төгрөгний орлого олсон, 23 орчим хувь нь нэгэн хэвийн орлоготой (орлого нь есдөггүй), 20 хувь нь орлого буурсан, 39 хувь нь орлого бага зэрэг өссөн гэсэн дүн гарсан байна.

Иймд хоршооллын хөдөлгөөнийг түгээн дэлгэрүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлоготой нийцүүлэн хоршоог дэмжих, хуульд заасан зорилго, зарчимд нийцсэн хоршоог байгуулах, улсын бүртгэлд бүртгэх, хариуцлага, дотоод хяналтыг нь сайжруулах шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хоршооллын хөдөлгөөнийг өрнүүлэн хөгжүүлэх замаар хоршооны үүрэг оролцоог нэмэгдүүлэн Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтыг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах зорилтыг хэрэгжүүлнэ:

2.2.1. хоршооны хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах;

2.2.2. төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, үр дүнг сайжруулах;

2.2.3. хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх;

2.2.4. хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих;

2.2.5. хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх.

2.3. Хөтөлбөрийг 2019-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Хоршооны хөгжлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.1.1. Хоршооны тухай хуулийг боловсронгуй болгож хөгжлийн өнөөгийн түвшинд нийцүүлэх;

3.1.2. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд мал аж ахуйн бүтээгдэхүүнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татварын үйлчлэлийн ялгааг арилгах;

3.1.3. хоршооны онцлогийг тусгасан нэмэлт, өөрчлөлтийг хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль тогтоомжид оруулах;

3.1.4. хөдөө аж ахуйн биржээр дамжуулан худалдан борлуулсан түүхий эдэд татварын хөнгөлөлт үзүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3.1.5. малчид, мал бүхий иргэдийн үндэсний үйлдвэрт нийлүүлсэн болон биржээр борлуулсан бүтээгдэхүүний урамшууллыг хоршоогоор дамжуулж олгох талаар холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах;

3.1.6. хоршооны салбарын эрх зүйн баримт бичигт мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар дүн шинжилгээ хийж, холбогдох санал боловсруулах;

3.1.7. хоршооны хөрөнгө өмчлөлийн онцлог байдлыг харгалзсан зээлийн журмыг хөнгөвчлөх асуудлыг шийдвэрлэх.

3.2. Төр болон хоршоог дэмжигч байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж үр дүнг сайжруулах зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.2.1. хоршооны хөгжлийн талаар төр, засгийн бодлогын залгамж чанарыг тогтвортой хадгалж ажиллах;

3.2.2. ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хүн амын хүнсний хангамжийг сайжруулах, хүнсний аюулгүй байдлыг хангах, байгаль орчны чиглэлийн төсөл, хөтөлбөрт хоршоодын оролцоог нэмэгдүүлэх;

3.2.3. хоршоодын мэргэжлийн болон үндэсний хэмжээний нэгдсэн холбооны чадавхыг дээшлүүлэх;

3.2.4. хоршоо, тэдний хөгжлийг дэмжигч байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, цар хүрээг өргөжүүлэх, мэдээлэл солилцоог сайжруулах, салбарын мэдээллийн санг баяжуулах, хоршоо хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх;

3.2.5. хоршоо, мэргэжлийн болон үндэсний хэмжээний холбооны үйл ажиллагааг уялдуулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх;

3.2.6. хоршоог дэмжих төрийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хангах, төрийн зарим чиг үүргийг хоршоологчдын холбоогоор гүйцэтгүүлэх.



3.3. Хоршоог хөрөнгө оруулалт, санхүү, зээлийн бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх замаар ажлын байр нэмэгдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.3.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтэд улсын төсвийн тодорхой хувийг хуваарилж байх;

3.3.2. хоршооны бүтээгдэхүүн борлуулалтын төв, хөдөө аж ахуйн болон жижиг, дунд үйлдвэрийн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн хангамжийн дундын цэгийг орон нутагт байгуулж, хоршоодын захиалгын дагуу нийлүүлэх тогтолцоог бүрдүүлэх;

3.3.3. ажлын байр нэмэгдүүлэх болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүжилтийн тодорхой хэсгийг хоршооны салбарын үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжихэд зарцуулах;

3.3.4. загвар хоршоог байгуулж, хөрөнгө санхүүгээр дэмжих;

3.3.5. орон нутгийн өмчлөлд байгаа ашиглагдахгүй барилга байгууламжийг хоршоонд түрээслүүлэх, эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.4. Хоршоогоор дамжуулан түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлт, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээний оновчтой тогтолцоог бий болгох замаар орон нутгийн хөгжлийг дэмжих зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.4.1. түүхий эд, бүтээгдэхүүний нийлүүлэлт, борлуулалтын сүлжээг хөгжүүлэх;

3.4.2. нийслэл, бүсийн төвд түүхий эд, бараа, бүтээгдэхүүний арилжаа, тээвэр ложистикийн төв байгуулж хоршоодын оролцоог нэмэгдүүлэх, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх;

3.4.3. үндэсний үйлдвэрт хоршоо бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх, харилцан ашигтай хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;

3.4.4. хоршоодын бэлтгэсэн малын гаралтай түүхий эдийг хөдөө аж ахуйн биржээр арилжих ажлыг эрчимжүүлэх;

3.4.5. түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төвийг хоршооны бүтцэд тулгуурлан сумдад байгуулах.

3.5. Хоршооны “Сайн засаглал”-ыг төлөвшүүлэн нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

3.5.1. хоршооны нийгэмд эзлэх байр суурь, үнэлэмжийг дээшлүүлэх;

3.5.2. хоршооны талаарх олон нийтийн хандлагад сэтгэл зүйн тандалт судалгаа хийж холбогдох арга хэмжээг авах;



3.5.3. төрийн худалдан авалтад өөрийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд хоршоод идэвх санаачилгатай оролцох;

3.5.4. хоршооны салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, залгамж үеийг төлөвшүүлэх;

3.5.5. хоршооны гишүүдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, дотоод хяналтыг сайжруулах;

3.5.6. хоршооны засаглалд хүйсийн тэгш байдлыг хангах.

Дөрөв. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

4.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ:

| № | Шалгуур үзүүлэлт | Хэмжих нэгж | Суурь түвшин (2019 он) | Зорилтот түвшин (2024 он) |
|-----|---|-----------------------------|------------------------|---------------------------|
| 1. | Хоршоод шинэчилсэн бүртгэлд хамрагдсан байх | хувь | 75 | 100 |
| 2. | Загвар хоршоо бий болох | сум/хоршооны тоо | 0 | 100 |
| 3. | Төрийн зарим чиг үүргийг хоршоодын холбоогоор гүйцэтгүүлсэн байдал | гүйцэтгэсэн ажлын тоо | 0 | 20 |
| 4. | Хоршооллын хөгжлийг дэмжсэн төсвийн санхүүжилтийн хэмжээ | төгрөг | 100 сая төгрөг | 15.0 тэрбум төгрөг |
| 5. | Хоршооны үйлдвэрлэл, үйлчилгээний парк, бүтээгдэхүүн борлуулалтын зориулалтын төв | тоо | 0 | 10 |
| 6. | Хоршоодын хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ | тэрбум төгрөг | 42.5 | 60.0 |
| 7. | Хоршооны борлуулалтын болон гишүүдэд хуваарилсан ногдол орлогын дүн | хувь | тодорхойгүй | 5 |
| 8. | Түүхий эд бэлтгэх, чанарын хамгаалалт, тордолт хийх төв | тоо | 0 | 100 |
| 9. | Үндэсний үйлдвэрт нийлүүлсэн бүтээгдэхүүн, түүхий эд нийлүүлсэн хоршооны тоо | хоршооны тоо/ өсөлтийн хувь | 0 | 15 |
| 10. | Биржээр түүхий эдээ арилжиж буй хоршоо | хоршооны тоо | 56 хоршоо | 200 |
| 11. | Улс, аймгийн шилдэг хоршоо | тоо | 48 | 70 |



Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

5.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ:

5.1.1. улсын болон орон нутгийн төсөв;

5.1.2. Засгийн газрын холбогдох тусгай сангийн хөрөнгө;

5.1.3. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл,

тусламж;

5.1.4. банк болон банк бус санхүүгийн байгууллагын эх

үүсвэр;

5.1.5. хууль тогтоомжоор хориглоогүй бусад эх үүсвэр.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт шинжилгээ, үнэлгээ

6.1. Хөтөлбөрийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүргийг хоршооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гүйцэтгэнэ. Шаардлагатай бол хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.

6.2. Хоршооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг дараа оны I улиралд багтаан Засгийн газарт танилцуулна.

6.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-дүүгүд, Төрийн ордон дүү тоот
И-мэйл: turiin_medecelel@parliament.mn

Утас: ᠒᠒᠒᠒᠒᠒

Хэвлэлийн хуудас: ᠔

Индекс: 200003